



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

26.23 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 07578

Улаанбаатар хот

С.Даваадоржид сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.8, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10 дугаар зүйлийн 10.4, 10.5, 10.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Улсын ахлах бүртгэгч Самбуунийн Даваадорж нь хуулиар хүлээсэн албан үүрэгтээ хариуцлагагүй хандаж, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг зөрчиж бүртгэл хөтөлсөн нь Авлигатай тэмцэх газрын 2023 оны 06/13903 дугаартай албан бичиг, хяналтын улсын байцаагчийн 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 5481 дугаар дүгнэлт, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул нь түүнд 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандaa холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын ахлах бүртгэгч С.Даваадоржид үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /Ө.Өлзийбаасан/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142303837